Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# “И-МОНГОЛ АКАДЕМИ” УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# “И-МОНГОЛ АКАДЕМИ” УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин /жилээр/ | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Алсын хараа 2050-ийн ХӨГЖЛИЙН БОДЛОГО БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ: Алсын хараа 2050-ийн хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.1, 5.3.2, Шинэ сэргэлтийн бодлогын 6.1, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 5.3, ЗГҮАХ-ийн 4.1, МУ-ын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 7.3** | | | | | | | |
| **НЭГ. Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой зөвлөгөө, мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд өгөх, төрөөс баримтлах бодлого, чиглэл, шийдвэрийн дагуу хөгжүүлж байгаа үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, хамтын ажиллагааг өргөжүүлэх** | | | | | | | |
| 1.1 | Төрийн үйлчилгээний нэгдсэн системтэй холбоотой иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэнэ. | - | Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо | 2839 | 2850 | Жилийн эцсийн байдлаар иргэд хуулийн этгээдээс ирсэн нийт **1489** өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэсэн. 2024 оны 5 сард e-mongolia 4.0 шинэчлэгдсэн хувилбараар дэд бүтцийг сайжруулж системийн алдаа, гацалт зэрэг асуудлууд сайжирсан тул өмнөх жил их ирдэг байсан иргэдийн гомдлууд буурсан.<br>Төрийн байгууллагатай хамтарч ажиллах ажлын хүрээнд **199** албан бичгээр хүсэлт ирүүлснээс **176** хүсэлтийг шийдвэрлэж, **32** хүсэлтийг судалж байна. Хавсралт-1 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2 | Иргэд олон нийттэй харилцах үйл ажиллагааны сайжруулалтын журам батлуулна. | | Журмын тоо | 0 | 1 | Хэрэглэгчийн үйлчилгээний хэлтсийн гарын авлага боловсруулж нийт хэлтсийн албан хаагчид мөрдөн ажиллаж байна. Мөн хувийн мэдээлэл задруулахгүй байх талаар нийт албан хаагчтай Нууцын гэрээ байгуулсан. Журам шинэчлэн батлуулсан. Хавсралт-2 | 100% |
| 1.3 | Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр илгээсэн үйлчилгээний төлбөрийн буцаалтыг шийдвэрлэнэ. | - | Хүсэлтийг шийдвэрлэсэн тоо | 486 | 566 | 2024 онд нийт **1294** иргэний төлбөрийн буцаалтыг шийдвэрлэсэн.<br>Дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргав. Хавсралт-3 | 100% |
| 1.4 | 1111-2 лавлах, TelcoCom системийн тайланд бүртгэгдэж буй дуудлагыг алдагдалгүй хариулна. | - | Алдагдалгүй дуудлагын хувь | 95% | 95% | Жилийн эцсийн байдлаар 1111-2 лавлах төвд нийт **139,772** дуудлага ирснээс **130,703** дуудлагад хариулж **98** хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. | 98% |
| 1.5 | Дээд газар болон удирдлагыг төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР), дэмжих системүүдийн үйл ажиллагаа, түүний хөгжүүлэлттэй холбоотой мэдээллээр хангаж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлнэ. | - | Тайлан мэдээллээр хангасан эсэх | - | 100% | • Дэмжих систем/ docx.gov.mn, esign.gov.mn/ болон хуульд заасан, ЗГ-аас шаардлагатай гэж үзсэн бусад систем/opendata.gov.mn, sudalgaa.gov.mn, lavlagaa.e-mongolia.mn, huduu.mn, reform.gov.mn, e-cabinet.gov.mn, shinehorshoo.gov.mn, consul.mn, shilenkhyanalt.gov.mn, kiosk.e-mongolia.mn /-үүдийн үйл ажиллагаа хөгжүүлэлттэй холбоотой асуудлаар дээд газар болон удирдлагыг тайлан мэдээллээр тогтмол ханган ажилласан.<br>• 14 хоног бүрийн хэлтсийн хүрээнд хийгдсэн ажлын нийт 25 удаагийн тайлан мэдээг удирдах дээд байгууллагад хүргүүлэн ажилласан.<br><br>Цаг үеийн шинжтэй хариуцсан системийн нийт 58 удаагийн тоон мэдээлэл, хөгжүүлэлтийн явцын талаарх мэдээлэл, тайланг боловсруулсан. | 100% |
| 1.6 | Төрийн цахим үйлчилгээний хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлнэ | - | Системд бүртгэлтэй хэрэглэгчийн тоо | 1,838,939 | 1,900,000 | Төрийн цахим үйлчилгээний систем хэрэглэгчдийн тоо 2024 оны жилийн эцсийн байдлаар **1,932,313** хүрсэн байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.7 | Олон нийтийг байгууллагын үйл ажиллагааны мэдээллээр хангах | - | Нийтлэгдсэн мэдээний тоо | - | 80 | **Мэдээллийн сайтуудад өгсөн мэдээ:**<br>– Mass.mn, Zarig.mn, Newspress.mn, Isee.mn, Itoim.mn, Shuud.mn, Gogo.mn, Mnb.mn, Ergelt.mn, Murch.mn, Ikon.mn, Zugii.mn, Tug.mn, Chig.mn, Tsahiur.mn, Shuurhai.mn, Amlalt.mn, Туг.мн, Mand.mn, Onlinetimemn.com , Төр.мн, 24 tsag.mn, Mpa.mn, Asu.mn, Erennews.mn, Business.mn, News.mn, Als.mn, Inder.mn, Tusgal.mn, Ubn.mn, Zindaa.mn, Shuurhai.mn, Eagle.mn, Dardas.mn, Montsame.mn, Gerelnews.mn, Ntv.mn мэдээллийн сайтуудаар нийт **100** мэдээг нийтлүүлсэн.<br>**Телевизийн нэвтрүүлэгт оролцсон байдал:**<br>– Б.Мягмарнаран, А.Батмандах, С.Тулга, Б.Дуламсүрэн, Н.Чингүн, Ө.Дашзэвэг, Б.Жаргалцэцэг нар нь өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээллээр ETV, MNB, C1, ULZII TV, EAGLE TV, TENGERTV, CENTRALTV, SBN , MONGOLHD TV, TV8, NTV телевизүүдээр ярилцлага мэдээлэл өгсөн.<br>**Радио:**<br>– MGL radio 88.3 -д 2024 оны 3 дугаар сараас 6 сарыг дуустал хамтран ажиллах гэрээ байгуулж төлөвлөгөөний дагуу Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia тухай мэдээллийг иргэдэд хүргэн ажиллаж байна.<br>– MNB Монголын үндэсний радио 2 удаагийн дугаарт оролцсон.<br>**Байгууллагын албан ёсны фейсбүүк (E-Mongolia academy) пейж хуудсанд**<br>– **199** мэдээ, сурталчилгаа байршуулсан.<br>**Байгууллагын албан ёсны Ema.gov.mn веб хуудсанд**<br>**52** мэдээ байршуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.8 | Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах үйл ажиллагаа зохион байгуулна. | - | Үйл ажиллагааны тоо | 4 | 6 | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia, хүүхэд хамгааллын E-Kids, "Цахим ур чадварын үндэсний аян"-г сурталчлан таниулах 8 удаагийн арга хэмжээг зохион байгуулсан.<br><br>1. "Цахимд хэвшье" Digital First-D1 арга хэмжээг 2024 оны 3 дугаар сарын 11-ны өдрөөс 5 дугаар сарын 03-ны өдөр хүртэл ЦХХХЯ-тай хамтран 21 аймагт зохион байгуулсан.<br><br>2. Цахим ур чадварын үндэсний аяныг Чингэлтэй дүүрэгт 04 дүгээр сарын 27-ны өдөр Ялалтын талбайд зохион байгууллаа.<br><br>3. 5 дугаар сарын 7-ны өдөр E-Mongolia 4.0 нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа.<br><br>4. Цахим ур чадварын үндэсний аяны хүрээнд 5 дугаар сарын 17-ны өдөр Чингис хааны үндэсний музейд DIGITAL YOUTH арга хэмжээг зохион байгууллаа.<br><br>5. "ЦАХИМ УР ЧАДВАРЫН ҮНДЭСНИЙ АЯН-UB MARATHON" арга хэмжээг 05 дугаар сарын 25-ны өдөр Сүхбаатарын талбайд зохион байгууллаа.<br><br>6. Цахим ур чадварын үндэсний аяны хүрээнд 5 дугаар сарын 30-ны өдөр "ХҮҮХЭД ТАНЫГ ХАМГААЛЪЯ" нээлттэй өдөрлөгт E-Mongolia, E-Kids-ыг сурталчлан оролцлоо.<br><br>7. 6 дугаар сарын 6-ны өдөр "Технологиор гэр бүлээ хамгаалъя E-Kids" шийдэл танилцуулах үйл ажиллагааг Novotel ballroom-д 10:00-11:30 хооронд зохион байгууллаа.<br><br>8. 11 дүгээр сарын 22-ны өдөр "Өгөгдлийн интеграци ХУР & ДАН шийдэл" төр хувийн хэвшлийн уулзалтыг PrimeCineplex-д зохион байгууллаа. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 9. 12 дугаар сарын 01-ний өдөр "Ability expo 2024" тусгай хэрэгцээт иргэдийн өдөрлөгт оролцсон. | |
| 1.9 | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем e-mongolia-н 4.0 хувилбарын нээлтийн үйл ажиллагаа компанит ажил зохион байгуулна. | - | Компанит ажлын тоо | 0 | 1 | 2024 оны 5 дугаар сарын 7-ны өдөр 10:00-12:00 цагийн хооронд ACEM– Хүн театрт E-Mongolia 4.0 нээлтийн үйл ажиллагааг "Хиймэл оюунд суурилсан, иргэнээ хамгаалдаг E-Mongolia 4.0" уриан дор амжилттай зохион байгуулсан. Тус ажиллагааны хүрээнд:<br>• Хот хоорондын нийтийн тээврийн 582 автобусны арын цонхонд E-Mongolia 4.0 стикер байршуулсан.<br>• Нийслэлийн 527 чиглэлийн автобусны сурталчилгааны дэлгэцээр E-Mongolia 4.0 хувилбарын шинэчлэлийн 4 төрлийн шторкийг байршуулсан.<br>• Skytel, Unitel, Mobicom, G-Mobile үүрэн телефоны оператор компаниудаар иргэдэд мессеж илгээсэн.<br>• Нийслэлд байршиж буй гадна талбайн 4 LED дэлгэцээр E-Mongolia 4.0 хувилбарын шинэчлэлийн 4 төрлийн шторкийг байршуулсан.<br>• CU сүлжээ дэлгүүрийн бүх дэлгэцээр E-Mongolia 4.0 хувилбарын 4 төрлийн шинэчлэлийн шторкийг байршуулсан.<br>• Нийслэл хотод байрлах орон сууцнуудын 1362 лифтний дэлгэцээр E-Mongolia 4.0 хувилбарын 4 төрлийн шинэчлэлийн шторкийг байршуулсан.<br>• Bussines.mn сэтгүүлийн 5 дугаар сарын тусгай дугаарыг бэлтгэж хэвлүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.10 | Цахим шилжилтийг зохион байгуулж буй төрийн болон бизнесийн байгууллагуудтай хамтран ажиллана. | - | Байгууллагын тоо | 8 | 16 | 2024 оны жилийн эцсийн байдлаар **2** олон улсын байгууллага, **37** төрийн байгууллага, **18** хувийн хэвшилтэй хамтарч ажилласан. Нийт **57** байгууллагатай хамтран ажилласан байна. **Хавсралт 4** | 100% |
| 1.11 | Төрийн цахим үйлчилгээг авах заавар бүхий цуврал контент бэлтгэх | - | Контентын тоо | 35 | 50 | Заавар бүхий видео - **19**<br>Заавар бүхий постер - **13**<br>Заавар бүхий рийл - **32**<br>Заавар бүхий контент - **6**<br>Нийт **70** зааврыг бэлтгэж хүргэсэн байна. | 100% |
| 1.12 | Байгууллагын албан ёсны нийгмийн сүлжээг хөтлөн мэдээ, мэдээлэл түгээнэ. | - | Постерын тоо | 75 | 80 | E-Mongolia фейсбүүк хуудсыг хөтөлж мэдээ, мэдээлэл хүргэсэн байдал.<br>– Постер - **130**<br>– Видео - **73**<br>– Рийл - **49**<br>– Стори - **160**<br>Нийт **412** мэдээ, мэдээллийг түгээж ажилласан байна. | 100% |
| **ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ: "Алсын хараа-2050"-ийн 5.3.1, Алсын хараа 2050-ийн хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.3, 5.3.4, Шинэ сэргэлтийн бодлогын 6.1, 6.3, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 5.3.3, 5.3.4, ЗГҮАХ-ийн 4.1.1, МУ-ын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 7.3, 7.4,** | | | | | | | |
| **ХОЁР. Цахим шилжилтийн стратеги, төлөвлөгөөний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, шинээр нэвтрүүлэх мэдээллийн технологийн төслийг салбарын бодлого, төлөвлөлт, стандарттай нийцүүлэх санал, зөвлөмж гаргах, ажлын даалгавар, техникийн нөхцөл боловсруулах** | | | | | | | |
| 2.1 | Төрийн үйлчилгээний нэгдсэн системд орсон орон нутгийн 125 үйлчилгээг дахин загварчлахад шаардлагатай судалгааг хийнэ. | - | Судалгаа хийсэн аймгийн тоо | 10 | 21 | Монгол Улсын Засгийн газрын "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулах, төрийн хүнд суртлыг бууруулах зорилтыг хэрэгжүүлэх болон Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/53 тоот тушаалаар батлагдсан "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 21 аймагт томилолтоор ажилласан. Орон нутгийн төрийн байгууллагуудаас хүн, хуулийн этгээдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг дахин загварчлах, шинээр нэвтрүүлэх үйлчилгээний процессын шинжилгээ, судалгаа хийж ажилласан. Дээрх судалгааны дагуу | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 21 аймгийн төрийн байгууллагуудаас Emongolia-д нэвтэрсэн 128 /1284 давхардсан тоогоор/ үйлчилгээ дотроос хасах 13 үйлчилгээ, хаанаас үзүүлэх нь тодорхойгүй байгаа буюу эзэнжүүлэх 7 үйлчилгээ, бүрдүүлбэрийг ижил болгох 66 үйлчилгээ, шинээр хөгжүүлж нэвтрүүлэх 139 үйлчилгээ, бусад байгууллагын системтэй интеграци хийж шинээр нэвтрүүлэх 154 үйлчилгээний судалгааг гаргаж ЦХХХЯ руу хүргүүлсэн. Уг ажлын дагуу мэдээлэл хариуцагч байгууллагуудтай хамтран 30 үйлчилгээнд дагалдах бүрдүүлбэр бичиг баримтыг бүх аймагт ижил болгож цэгцэлсэн. Мөн орон нутгийн чанартай 100 үйлчилгээг аймгуудад нэвтрүүлсэн. Жич: Энэхүү 100 үйлчилгээ нь зарим аймагт байдаг боловч зарим аймагт нэвтрээгүй байсан тул хүсэлт гаргасан аймгуудад нэмж нэвтрүүлсэн. Хавсралт-5 | |
| 2.2 | Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргана. | - | Зөвлөмж, дүгнэлт гаргасан тоо | 8 | 17 | 7 байгууллагын 8 системд зөвлөмж дүгнэлтийг гаргаж ЦХХХЯ-нд хүргүүлсэн байна. Үүнд:<br>1. ЦЕГ-ын 102 аппликейшнд,<br>2. ЭЗХЯ-ны Хилийн удирдлагын систем,<br>3. Төв аймгийн ЗДТГ-ын Цахим төв аймаг систем,<br>4. Соёлын яамны Соёлын эрхийн бичгийн системийн ажлын даалгавар, Оюуны өмчийн бүртгэлийн системийн ажлын даалгавар,<br>5. СХЗГ-ын LIMS систем,<br>6. ЗТХЯ-ны RFID систем<br>7. НХТГ-ын Төвлөрсөн хогийн цэгүүдийн хог бүртгэлийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформ. Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаар оруулав. Хавсралт 6-11 хүртэл | 82% |
| 2.3 | Эрүүл мэндийн салбарын цахим системүүдэд шинжилгээ хийнэ. | - | Шинжилгээ хийсэн эсэх | 0 | 10 | Эрүүл мэндийн салбар байгууллагуудад ашиглагдаж буй дараах системүүдэд шинжилгээ хийж Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны нэгдсэн системд холбосон. Үүнд:<br>1. "Health.gov.mn"<br>2. "H-Info.mn" | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3. "E-health"<br>4. "Medsoft"<br>5. "Wings Pos"<br>6. "Andmed"<br>7. "Karte.mn"<br>8. "Caritas"<br>9. "eClinic"<br>10. "licemed.mohs.mn"<br>Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаар оруулав. Хавсралт-12 | |
| 2.4 | Тодорхой салбар, байгууллагын цахим системийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, арга зүйн зөвлөгөө өгч, хамтран ажиллана. | - | Хамтран ажилласан салбар байгууллагын тоо | 86 | 90 | Засгийн газрын 16 яам, түүний харьяа байгууллагуудтай өдөр тутам мэдээлэл солилцож ажилладаг бөгөөд 77 байгууллагатай хамтарч ажиллах албан хүсэлтийг илгээгээд байна. Төрийн байгууллагатай цахим системийг хөгжүүлэх мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор 24 удаагийн уулзалтыг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулав. | 100% |
| 2.5 | Төрийн байгууллагуудад ашиглагдаж буй цахим системүүдийн судалгааг хийнэ. | - | Судалгааны тоо | 0 | 19 | ЦХИХХЯ болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газартай хамтран төрийн байгууллагуудад хэрэглэгдэж буй системийн судалгааг, өөрсдийн санаачлагаар програм хангамжийн лицензийн судалгааг хийсэн.<br>Мөн Засгийн газрын 2023 оны 100, 233 дугаар тогтоолын хүрээнд 12 төрийн байгууллагын системүүдэд судалгаа хийв. Хавсралт 13 | 100% |
| **ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ: "Алсын хараа-2050"-ын 5.3.1, Алсын хараа 2050-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.3, 5.3.4, Шинэ сэргэлтийн бодлогын 6.1 , МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 5.3.3, 5.3.4, ЗГҮАХ-ийн 4.1.1, МУ-ын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 7.3, 7,4,** | | | | | | | |
| **ГУРАВ. "Төр, хувийн хэвшлийн дундын мэдээлэл солилцооны систем, түүнийг дэмжих системүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах, хөгжүүлэх" зорилгын хүрээнд** | | | | | | | |
| 3.1 | ХУР системд мэдээлэл солилцох сервисийг хөгжүүлж тоог нэмэгдүүлнэ. | - | Сервисийн тоо | 668 | 718 | Төрийн мэдээлэл солилцооны ХУР системд нийт **813** сервис хэвийн ажиллаж байна. Энэ онд 17 байгууллагын 140 сервис хөгжүүлэгдэж орсон байна. Үүнд<br>Хөдөлмөр халамж, үйлчилгээний ерөнхий газар \| 7 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үндэсний дата төв 1<br>Төрийн албаны зөвлөл 5<br>Зам, тээврийн хөгжлийн яам 1<br>Эрүүл мэндийн хөгжлийн төв 6<br>Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар 5<br>Нийгмийн даатгалын ерөнхий газар 5<br>Улсын бүртгэлийн ерөнхий газар 18<br>Гадаадын иргэн харьяатын газар 3<br>Албан журмын даатгагчдын холбоо 4<br>E-Mongolia 5<br>Эрүүл мэндийн яам 29<br>Нийслэлийн Цахим хөгжил мэдээллийн технологийн газар 2<br>Хил хамгаалах ерөнхий газар 3<br>Боловсролын мэдээллийн технологийн Төв 1<br>ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР 3<br>Авто тээврийн үндэсний төв 3 | |
| 3.2 | Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн үйлчилгээний тоог нэмэгдүүлнэ. | - | Үйлчилгээний тоо | 1,033 | 1,210 | Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн үйлчилгээний тоо 1263 болж нэмэгдсэн байна. Тухайн тайлан мэдээг 7 хоног бүр ЦХИХХЯ руу хүргүүлж ажилладаг. | 100% |
| 3.3 | Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ERP-г төрийн байгууллагуудад нэвтрүүлнэ. | - | Шинээр ERP нэвтрүүлсэн байгууллагын тоо | 2067 | 2167 | Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийг шинээр 876 байгууллагуудад нэвтрүүлсэн байна. | 100% |
| 3.4 | "Их өгөгдлийн (big data) сан" бүрдүүлэхэд шаардлагатай мэдээлэл дамжуулах серверүүдийг хөгжүүлнэ. | - | Сервисийн тоо | 0 | 1 | Эрүүл мэндийн цахим шилжилт, Эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэхэд зориулан ЭМДЕГ-тай хамтран нийт 3 сервис, ЭМХТөвтэй хамтран 2 сервис хөгжүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.5 | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-mongolia платформын аппликейшн болон веб сувгуудын 4.0 хувилбарыг хөгжүүлнэ. | - | Хөгжүүлсэн хувилбар | 3.0 | 4.0 | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-mongolia платформын аппликейшн болон веб сувгуудын 4.0 хувилбарыг хөгжүүлж 2024 оны 5 сарын 7-нд нэвтрүүлсэн. E-mongolia платформын аппликейшн 4.0 хувилбарын хөгжүүлэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргав.<br>Хавсралт-14 | 100% |
| 3.6 | Төрийн үйлчилгээний төлбөр тооцооны нэгдсэн систем хөгжүүлнэ. | - | Нэвтрүүлсэн системийн тоо | бүёч0 | 1 | Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдааны 45 дугаар тэмдэглэлийн хүрээнд хэрэглэгч үйлчилгээний төлбөрийг өөрийн банкны картаар хялбар төлөх боломжийг бүрдүүлэх ажил хийгдэж эхэлсэн. И Монгол академи нь Төлбөрийн системийн оролцогч биш учраас Сангийн яамны TSP системээр дамжуулан холбогдохоор хамтран ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд e-mongolia app wallet цэсээр банкны карт бүртгэх дизайн гарсан. Дизайны дагуу хөгжүүлэлт хийхэд шаардлагатай сервисүүдийг Сангийн яамаас авсан. Үүнд: карт бүртгэх боломжтой эсэхийг лавлах eligible, карт токенжуулах хүсэлт илгээх approve, карт бүртгэх, бүртгэсэн картаар гүйлгээ хийх, хийсэн гүйлгээг буцаах зэрэг сервисүүд байна. Эдгээр сервис бүрээр карт бүртгэхээс гүйлгээ хийх хүртэл бүтэн үйл ажиллагааг ХХБ, Голомт банк-ны картаар тест орчинд турших 2024.05.31 өдөр амжилттай дууссан. Сервисүүдийг front хөгжүүлэлттэй холбох ажил бүрэн хийгдсэн.<br>TSP системийн холболтыг бодит орчинд оруулахаас өмнө Сангийн яамны Төрийн сангийн газрын төрийн үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэл үүсгэх, төлбөр төлөх QR code үүсгэх, банкны аппликэйшн руу үсрэх deep link авах 3 сервисийг ашиглах шаардлага үүссэн. Эдгээр 3 сервисийг бодит орчинд оруулахаас өмнө стресс тест хийхэд Сангийн яамны нэхэмжлэл үүсгэж буй систем down болсон. Дахин стресс тест хийж амжилттай болсоны дараа бодит орчинд оруулахаар ажиллаж байна. | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.7 | Мэдэгдэл хүргэх системийн 2.0 хувилбарыг нэвтрүүлж ХУР болон И Монгол платформуудын мэдэгдэл хүргэх сувгуудыг сайжруулна. | - | Нэвтрүүлсэн хувилбар | 1.0 | 2.0 | Мэдэгдэл хүргэх системийн 2.0 хувилбарыг хөгжүүлэв. Тус шинэчлэсэн хувилбарт 4 сувгаар мэдэгдэл илгээх боломжтой. Үүнд<br>• Үндэсний цахим шуудан<br>• Хувийн цахим шуудан<br>• Фэйсбүүк чат<br>• Мобайл апп push мэдэгдэл<br>Бусад байгууллагын системтэй холболт хийж цаг алдалгүй мэдэгдэл хүргэх боломжийг бүрдүүлсэн байна. Нийт мэдэгдэл хүргэсэн тоо:<br>• Үндэсний цахим шуудан - 4,478,670<br>• Хувийн цахим шуудан - 222,805<br>• Фэйсбүүк чат - 18,465<br>• Мобайл апп push мэдэгдэл - 14,411,618<br>Гэрээ байгуулж холболт хийсэн системийн тоо 24 байна. | 100% |
| 3.8 | Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /ERP/-д төрийн байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу шаардлагатай хөгжүүлэлтийг хийнэ. | - | Нэмэлт хөгжүүлэл-тийн тоо | - | 1 | Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системтэй холбоотой асуудлуудад хариу өгч, хөгжүүлэлтүүдийг тухай бүрт нь оруулж хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажилласан. | 100% |
| 3.9 | Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /ERP/-ийн мобайл апп хувилбарын дизайн шинэчлэх хөгжүүлэлт хийнэ. | - | Нэмэлт хөгжүүлэл-тийн тоо | - | 100% | Мэдээллийн аюулгүй байдлыг газраас ирүүлсэн эмзэг байдлуудыг засах зөвлөмжийн дагуу дараах хөгжүүлэлтүүдийг хийсэн.Үүнд:<br>• Root detection<br>• Emulator detection<br>• Runtime integrity checks<br>ЦХИХХЯ-наас ирүүлсэн зөвлөмжийн дагуу дараах хөгжүүлэлтүүдийг оруулсан.Үүнд:<br>1. Мэдэгдэл хэсэгт албан бичиг ялгаж харуулах<br>2. Албан бичгийн дэлгэрэнгүй харуулах<br>3. Албан бичиг шийдвэрлэх, шилжүүлэх, буцаах боломжтой болгох<br>4. Зочин бүртгэлийн хэсэгт зочин таних<br>5. Робот машин дээр зочин хэрэглэгч ашиглах боломжтой болгож хөгжүүлэх | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 6. flutter 3.16.0 version болгож upgrade хийх | |
| 3.10 | Албан бичиг солилцооны дундын систем (docx)-д захиалагчаас ирүүлсэн шаардлагын дагуу хөгжүүлэлт хийнэ. | - | Нэмэлт хөгжүүлэлтийн тоо | - | 100% | • Албан бичиг солилцооны дундын системд 17 Албан хэрэг хөтлөлтийн системийн холболт хийсэн. 2345 төрийн байгууллага холболтоо хийсэн бичиг солилцож байна. Тус системтэй холбоотой тайланг 7, 14 хоногоор гаргаж төрийн байгууллагуудыг мэдээллээр хангаж ажилласан.<br>• ЦХХХЯ, Архивын ерөнхий газартай хамтарсан уулзалт хийж дата дүүрэх асуудлыг нэг жил тутам устгаж байхаар шийдвэрлэсэн.<br>• Тайлангийн хугацаанд системтэй холбоотой гарсан 68 асуудалд заавар зөвлөгөө өгч ажилласан.<br>• DocX системд нэвтрэх бүртгүүлэх үйл ажиллагаа болон DocX системд албан хэрэг хөтлөлтийн системээр бүртгүүлж, холбогдох үйл ажиллагааны зураглалыг шинэчилэн боловсруулсан гэх мэт ажлууд хийгдсэн. | 100% |
| 3.11 | Нээлттэй өгөгдлийн нэгдсэн платформ (opendata.gov.mn)-ын 2.0 хувилбарыг гүйцэтгэгчээс хүлээн авч бааз хөрвүүлэлтийн ажил хийнэ. | - | Нэвтрүүлсэн хувилбар | 1.0 | 2.0 | • Нээлттэй өгөгдлийн нэгдсэн платформ (opendata.gov.mn)-ын 2.0 хувилбарыг хийлгэх ажлын хүрээнд захиалагч, гүйцэтгэгч талуудтай 2 удаагийн шийдлийн уулзалт хийсэн.<br>• Шинэ хувилбартай холбоотой асуудлаар Opendata 1.0 хувилбараас хуучин датаг 2.0 хувилбар луу зөөх ажлын хүрээнд хуучин датабаазын өгөгдлийн файлын замыг заах ажлыг гүйцэтгэсэн.<br>• Opendata 2.0 хувилбарын git.ema.gov.mn дээрх project болон st.opendata.gov.mn staging server бий болгосон. | 100% |
| 3.12 | Нээлттэй өгөгдлийн нэгдсэн платформ (opendata.gov.mn)-д захиалагчаас ирүүлсэн хөгжүүлэлтийг хийнэ. | - | Нэмэлт хөгжүүлэл-тийн тоо | - | 100% | Opendata 2.0 хувилбарын серверийн хандах эрх аваагүй байгаа тул гүйцэтгэгчийн хөгжүүлэлт дуусаж хэвийн болох хүртэл ЦХИХХЯ-аас чиглэл хүлээж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.13 | Үндэсний судалгааны нэгдсэн платформ/sudalgaa.gov.mn/-д API вэб холболтууд хийнэ. | - | Холболт хийсэн тоо | 0 | 1 | Үндэсний судалгааны нэгдсэн платформ/sudalgaa.gov.mn/-д тухайн байгууллагуудтай API холболт хийх хөгжүүлэлтийг хийж дууссан. Хариуцагч ТБҮХорооноос холболт хийх байгууллагуудын мэдээлэл ирүүлсэн тохиолдолд системд холболт хийнэ. | 100% |
| 3.14 | Үндэсний судалгааны нэгдсэн платформ/sudalgaa.gov.mn/-д захиалагчаас ирүүлсэн шаардлагатай хөгжүүлэлтийг хийнэ. | - | Нэмэлт хөгжүүлэл-тийн тоо | - | 100% | ТБҮХ-оос ирүүлсэн Үндэсний судалгааны нэгдсэн платформ "sudalgaa.gov.mn"-ийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хийх боломжтой ажлуудыг эрэмбэлэн дараах хөгжүүлэлтүүдийг оруулсан. | 100% |
| 3.15 | Засгийн газрын хуралдааны систем /e-cabinet/-ийн 2.0-ийг нэвтрүүлнэ. | - | Нэвтрүүлэлт-ийн тоо | - | 100% | ЗГХЭГ-ын МТГ-аас өгсөн чиглэлийн дагуу 2024 оны 08 сарын 16-нд нэвтрүүлэх ажлын хүрээнд дараах ажлууд хийж нэвтрүүлсэн.Үүнд:<br>• Тагнуулын ерөнхий газраас 2 удаа хийсэн Аюулгүй байдлын үзлэгийн дагуу ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийг хангаж дүгнэлт гаргуулсан.<br>• Системд хийгдсэн хөгжүүлэлтийн дагуу хэрэглэгчийн тестийг тухай бүр хийж гүйцэтгэсэн.<br>• Нэвтрүүлэлтийн үед тараах материал бэлтгэсэн.<br>• Домайн нэр болон дата баазын асуудлыг ҮДТ-тэй хамтран гүйцэтгэсэн.<br>• 2019-2024 оны датаг хөрвүүлж баазруу хуулсан.<br>• ЗГХЭГ-тай хамтран нэвтрүүлэлтийн өмнөх тест хийн алдааг засварлан ажилласан.<br>• 2.0 хувилбарыг засварлаж, нэвтрүүлэх ажлын хүрээнд мобайл хувилбар дээр дараах хөгжүүлэлтүүдийг хийсэн. Үүнд:<br>○ App Store платформ дээр апп байршуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ○ Аппыг зөвхөн зорилтот хэрэглэгчид татаж авч болохоор нууцлалын тохиргоо хийсэн.<br>○ 2 алхамт баталгаажуулалтын шийдлийг нэвтрүүлсэн. Хэрэглэгч мэйлээр баталгаажуулалт хийж нэвтрэх боломжтой болсон.<br>○ Хуралдааны сонордуулгыг цаг тухайд нь илгээх боломжийг хөгжүүлсэн.<br>○ Хэрэглэгчийн лог мэдээллийг, төхөөрөмжийн мэдээлэл болон UUID дугаарын хамт бүртгэдэг болсон.<br>○ Дизайний сайжруулалтыг хийсэн. | |
| 3.16 | Засгийн газрын хуралдааны систем /e-cabinet/-; захиалагчаас ирүүлсэн хөгжүүлэлтүүдийг хийнэ. | - | Нэмэлт хөгжүүлэлтийн тоо | - | 100% | Захиалагч талаас Портал болон Мобайл хувилбар дээр шаардлагатай гэсэн нэмэлт хөгжүүлэлтүүдийг тогтмол хийсэн. | 100% |
| 3.17 | Тоон гарын үсгийн цахим хуудас /Esign.gov.mn/-ы дизайн өөрчлөх нэмэлт хөгжүүлэлт хийнэ. | - | Нэмэлт хөгжүүлэлтийн тоо | - | 100% | • Тоон гарын үсгийн клиент програм дээр гарч байгаа 96 асуудалд заавар зөвлөгөө өгч ажилласан.<br>• Монпасс ХХК-аас ирсэн хүсэлтийн дагуу шинэ сертификатыг MAC-OS хувилбар дээр нэмсэн.<br>• “Дан” танилт нэвтрэлтийн системд нэвтрэхэд “Тоон гарын үсгийн мэдээлэл олдсонгүй” гэсэн алдаа зааж байгааг шалгаж Гэрчилгээжүүлэгч байгууллагад мэдэгдэж засварласан.<br>• “ХУР” төрийн мэдээлэл солилцооны системээс мэдээлэл хайхад Тоон гарын үсгийн зөрүүтэй байна гэсэн алдааг шалгаж, тестлэн Тоон гарын эзэмшигчид заавар зөвлөгөөг өгч ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Нью компасс ХХК-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2024 онд шинээр авсан олгох гэрчилгээх Esign клиент програм дээр нэмсэн. | |
| 3.18 | Хариуцсан системүүдийн программчлалын уламжлалт архитектурыг шинэчилж микро сервис бүтэцтэй болгоно. | - | Системийн тоо | 3 | 5 | • Мэдэгдэл хүргэх системийн 2.0 хувилбарыг микро сервис бүтэцтэйгээр зохиомжлон найдвартай үйл ажиллагааг ханган ажиллаж байна.<br>• www.gov.mn бодит орчинг бэлдсэн. Admin 3ш, worker 10ш, web 4ш, file 1ш server - үүдийг ҮДТ дээр байрлах виртуал орчинд үүсгэж үйлдлийн систем суулгаж Cluster-т оруулсан. Серверүүд дээр хийгдэх тохиргоонуудыг хийж бэлэн болгосон. | 100% |
| 3.19 | Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 стандартыг байгууллагын хэмжээнд нэвтрүүлсэн байна. | - | Нэвтрүүлсэн эсэх | 0 | 1 | Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэхээр ажлын хэсэг шинэчлэн байгуулж, стандартын бичиг баримтыг боловсруулан ажилласан. Тус стандартын баталгаажуулалтын аудит хийгдэж байна. Хавсралт 15 | 100% |
| 3.20 | Программ хангамжийн туршилтыг автоматжуулах технологийн шийдлийг нэвтрүүлнэ. | - | Туршилтыг автоматаар хийх технологийн шийдэл нэвтрүүлсэн эсэх | 0 | 1 | Хөгжүүлэлтийн кодын ажиллагааг шалгах автомат хэрэгсэл болох Sonarcube-ийг эх код удирдлагын системтэй хамтран ажиллах боломжтой болlгож, хөгжүүлэлтийн эх код стандартын дагуу эсэхийг шалгаж оруулдаг болсон. | 100% |
| 3.21 | Газрын хариуцсан системүүдэд ачаалал даах чадварын үнэлгээг хийнэ. | - | Үнэлгээ хийгдсэн системийн тоо | 2 | 4 | Доорхи системүүдийн ачаалал даах чадварын туршилт хийв. Үүнд:<br>• Төрийн нэгдсэн цахим хуудас gov.mn<br>• E-mongolia payment төрийн төлбөр тооцооны системийн<br>• E-mongolia хуулбар өгөгдлийн сан | 100% |
| 3.22 | Нэгтгэсэн хяналтын системд ороогүй системүүдийн сервисийг шат дараатай оруулна. | - | Сервисийн тоо | 224 | 250 | Доорхи системүүдийг хяналтын системд оруулж шинээр хөгжүүлсэн. Үүнд:<br>• Мэдэгдэл хүргэх систем | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • ХУР мэдээлэл солилцооны системийн доголдол тасалдалын мэдээлэл харуулах хяналтын самбар<br>• ХУР системд мэдээлэл нийлүүлэгч байгууллагын системийн холболтууд | |
| 3.23 | Системийн хөгжүүлэлт, нэвтрүүлэлт, хэвийн найдвартай ажиллагааг хангах журамд нэмэлт өөрчлөлт оруулах төслийн санал боловсруулна | - | Баримт бичгийн тоо | - | 1 | Системийн ашиглалт үйлчилгээний журмыг шинэчлэн батлуулах журмын төслийг боловсруулсан. | 100% |
| 3.24 | Газрын хариуцсан системүүдийн дата-г нэгтгэсэн, бодит цагийн горимтой дашбоардах системийн тоог нэмнэ. | - | Системийн тоо | 8 | 9 | Тус ажлын хүрээнд бодит цагийн шинэчлэлт бүхий хуулбар өгөгдлийн сан үүсгэх, турших ажлыг амжилттай дуусгасан.<br>Microsoft PowerBi ашиглан e-mongolia системийн 7 хоног бүр тогтмол илгээдэг тайлангийн өгөгдөл мэдээлэлд зориулж дашбоард хөгжүүлсэн. | 100% |
| 3.25 | Системийн гэмтэл, саатлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулна. | - | Төлөвлөгөөний тоо | 0 | 1 | Системийн ашиглалт үйлчилгээний журмыг шинэчлэн батлуулах ажлыг ахлан журмын төслийг боловсруулсан. | 100% |
| 3.26 | Төрийн үйлчилгээний нэгдсэн платформын нөөц системийг бий болгоно. | - | Нөөц системийн тоо | 0 | 1 | Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн хэвийн ажиллагааг хангах хүрээнд төлөвлөгөө гаргаж тус системийн өгөгдлийн сангийн толин баазын үүсгэх хэвийн шинэчлэлттэй байх ажлын зохион байгуулан ажилласан. | 100% |
| 3.27 | ХУР, ДАН системийг сурталчлах арга хэмжээ зохион байгуулна. | - | Арга хэмжээний тоо | 0 | 1 | ЦХИХХЯ, Үндэсний дата төв УТҮГ-тай хамтран "Өгөгдлийн интеграци - ХУР,ДАН шийдэл 2024" төр, хувийн хэвшлийн хамтарсан уулзалт арга хэмжээг 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулж, ХУР, ДАН системүүдийн шинэчлэл, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар танилцуулж, оролцогчдын саналыг авсан. | 100% |
| **ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ: "Алсын хараа 2050"-ийн хүрээнд 7.5.7, 7.5.10, 7.5.16, 2021-2030 оны хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.1.5, 2.1.43, 2.1.44, 5.4.14; МУ-ын ЗГҮАХ-ийн 2020-2024 оны 2.3.12, 4.1.5, 4.1.7;** | | | | | | | |
| **ДӨРӨВ. "Бүх нийтийн мэдээллийн технологийн ур чадварыг дээшлүүлэх сургалт, хөтөлбөр зохион байгуулах"** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1 | Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулна. | - | Батлагдсан хөтөлбөр | 1 | 1 | Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг 2023 оны судалгаанд үндэслэн шинэчлэх ажлыг төлөвлөгөөний дагуу боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>Мөн дараах хөтөлбөрүүдийг боловсруулж, батлуулсан. Үүнд:<br>– Төрийн байгууллын албан бичиг солилцооны дундын систем /Docx/-ийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, "И-Монгол академи" УТҮГ-ын захирлын 2024 оны 9 дүгээр сарын 9-ний А/94 тоот тушаалаар батлагдсан.<br>– Төрийн байгууллын нэгдсэн цахим хуудас /www.gov.mn/-ийг таниулах ашиглах сургалтын хөтөлбөрийг боловсруулж, "И-Монгол академи" УТҮГ-ын захирлын 2024 оны 10 дугаар сарын 8-ний А/105 тоот тушаалаар батлагдсан.<br>Хавсралт 16 | 100% |
| 4.2 | Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын агуулга, контент боловсруулна. | - | Контентын тоо | 5 | 10 | Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын агуулга, контентыг боловсруулсан. Үүнд:<br>– Иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааны 63 мэдээг фейсбүүк хуудаст www.facebook.com/emongolia.academy, 6 мэдээг фейсбүүк хуудаст www.facebook.com/emongolia-д бэлтгэж нийт 69 мэдээ оруулсан.<br>– **"Цахим ур чадварын үндэсний аян"**-ы 6 видеоны агуулгыг бэлтгэж, Маркетингийн хэлтэст хүлээлгэн өгч, агуулгаар нь нэгтгэн 3 видео болон нийтлэгдсэн. Мөн сургалт, үйл ажиллагааны мэдээ бүхий 9 видео, 7 сурвалжлага, ярилцлага, явцын видео нийтлэгдсэн.<br>– "Цахим иргэн", "Мэдээллийн аюулгүй байдал", "Албан бичиг солилцооны дундын систем DOCX", "Digital First D-1 цахимд хэвшье - Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх багц сургалт" зэрэг нийт 4 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалтын агуулга бүхий хэрэглэгдэхүүн боловсруулсан.<br>– Business.mn сэтгүүлийн тусгай дугаарыг "И-Монгол академи" УТҮГ, "Цахим ур чадварын аян"-ы талаар мэдээлэл, нас насны сегментед зориулсан зөвлөгөө, цахим орчин дахь хүүхэд хамгаалал зэрэг агуулгаар 18 хуудас бүхий контент боловсруулсан. Business.mn сэтгүүл нийт 8000 ширхэг хэвлэгдсэн.<br>– Багануур дүүргийн иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх "ЦАХИМ ИРГЭН" зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хамтран ажиллах хүрээнд "Иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх зорилтот төслийн гарын авлага" боловсруулсан.<br>– Цахим ур чадварын үндэсний аяны хүрээнд www.digital.edu.mn вэбсайтыг нээж, техникийн даалгаварыг шинэчлэн боловсруулж, вэбсайтын агуулгад контент боловсруулах, хөгжүүлэлт, сайжруулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.<br>Хавсралт-17 | |
| 4.3 | Насанд хүрэгчдэд зориулсан мэдээлэл технологийн ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж, батлуулна. | - | Батлагдсан хөтөлбөр | 0 | 1 | Иргэний мэдээлэл харилцаа холбоо, технологийг ашиглах, мэдээлэлтэй ажиллах, мэдээллийн болон сүлжээний аюулгүй байдлаа хангах, өөрт хэрэгтэй үйлчилгээг цахимаар авах, тулгарсан асуудлаа шийдвэрлэх, нийгмийн сүлжээнд ёс зүйтэй оролцох зэрэг ур чадварыг хөгжүүлэх зорилгоор Боловсролын ерөнхий газрын дарга, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирлын хамтарсан 2023 оны А/453, А/110 дугаар тушаалаар "НАСАНД ХҮРЭГЧДЭД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО, ТЕХНОЛОГИЙН БОЛОВСРОЛ"-ЫН СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨР"-ийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэгт орж ажиллан, хөтөлбөрийн боловсруулж, салбарын бүрийн төлөөлөлд 4 удаагийн хэлэлцүүлэг хийсэн. Хөтөлбөр нь 3 модуль, 11 сэдвээс бүрдэж байгаа бөгөөд БСҮХ-ийн захирлын 2024 оны 9-р сарын 25-ны өдрийн А/57 тоот тушаал батлагдсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.4 | Иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулна. | - | Сургалтад хамрагдсан иргэдийн тоо | 2,467 | 3,000 | Иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагатай хамтран танхим болон цахимаар зохион байгуулж, Нийт 114 удаагийн 352,5 цагийн сургалтад нийслэлээс 2059 иргэнд, орон нутгаас 801 иргэнд, нийт 2860 иргэнд тахимаар хүрч ажилласан.<br>Цахим ур чадварын аяны хүрээнд зохион байгуулагдах сургалтын хөтөлбөрийг боловсруулж, "И-Монгол академи" УТҮГ-ын захирлын 2024 оны 05 сарын 03-ны өдрийн А/61 тоот тушаалаар батлагдаж, хэрэгжилтийг ханган ажилласан.<br>Хавсралт 18 | 100% |
| 4.5 | Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулна. | - | Сургалтад хамрагдсан иргэдийн тоо | 2,000 | 2,500 | Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг Төрийн захиргааны төв байгууллага, Төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн ЗДТГ, НТБТ, ЕБС болон бусад газруудтай хамтран 127 удаагийн 173 цагийн сургалтад 4694 албан хаагчдад танхимаар, 2203 албан хаагчдад цахимаар нийт 6897 удирдлага, албан хаагчдад хамрагдсан байна. Сургалтаар Албан бичиг солилцооны дундын систем, Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас, Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем, Мэдээллийн аюулгүй байдал, Төрийн үйлчилгээ зэрэг агуулгыг багтаасан. | 100% |
| 4.6 | Цахим ур чадварын сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулна. | - | Сургагч багшийн тоо | 35 | 100 | 2024 онд нийт цахим ур чадварын 239 сургагч багшийг бэлтгэсэн.<br>• Багануур дүүргийн иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх "ЦАХИМ ИРГЭН" зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хамтран ажиллах хүрээнд тус дүүргийн 11 багшийг сургагч багшаар бэлтгэсэн.<br>• Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа "Ухаалаг засаг-2" төслийн хүрээнд 5 удаагийн сургалтыг зохион байгуулж, 130 сургагч багш бэлтгэсэн.<br>• "И-Монгол академи" УТҮГ-ын ЦУЧГ, Багануур дүүргийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран 98 сургагч багш бэлтгэх 4 удаагийн сургалтыг зохион байгуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Боловсролын ерөнхий газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, “И-Монгол академи” УТҮГ-ын Цахим ур чадварын газар хамтран “Насанд хүрэгчдэд зориулсан мэдээлэл, харилцаа холбооны технологийн боловсрол”-ын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургагч багш бэлтгэх онол, практик хосолсон арга зүйн сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс 10 дугаар сарын 09-ний өдрүүдэд Техник технологийн дээд сургуульд зохион байгуулж, 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн 50 багш хамрагдлаа. Тус сургалтын хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэгт “И-Монгол академи” УТҮГ-ын Цахим ур чадварын газрын Сургалтын хэлтсийн дарга В.Лут-Очир ажиллаж, сургагч багш бэлтгэхэд сургагч багшаар ажиллалаа. | |
| 4.7 | Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх “АЯН”-ыг зохион байгуулна. | - | = | 0 | 1 | Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 11 дүгээр 15-ны өдрийн 46 дугаар тэмдэглэлд бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус үүрэг болгосон.<br>Дээрх бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд "И-Монгол академи" УТҮГ-аас "Цахим ур чадварын үндэсний аян"-ыг бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлж, тоон хуваагдлыг бууруулан цахим шилжилтийн бэлэн байдлыг хангах зорилгоор Нийслэлийн 9 дүүрэгт 2024 оны 04 дүгээр сарын сарын 01-ээс 07 дугаар сарын 10-ны хооронд зохион байгуулан ажиллаж байна. Аяны хүрээнд:<br>• Олон нийтийн 4 арга хэмжээ /*”Цахим ур чадварын аяны нээлттэй хаалганы өдөр”, “DIGITAL YOUTH”, “Цахим ур чадварын үндэсний аян-UB Marathon", "Хүүхэд таныг хамгаалъя"*/ зохион байгуулж 30000 гаран иргэнд хүрч ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Мөн явуулын үйлчилгээг үзүүлж, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-тай холбоотой заавар зөвлөгөө, цахим ур чадварын талаарх мэдээллийг хүн ам төвлөрсөн нийт 33 байршилд хүрч ажилласан байна.<br>• Цахим ур чадварын сургалтыг 2062 төрийн албан хаагч, иргэдэд зохион байгуулсан. | |
| 4.8 | Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ. | - | Хамтран ажилласан байгууллагын тоо | 55 | 65 | 2024 онд бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааны чиглэлээр олон улсын 2, төрийн 469, хувийн хэвшлийн 9, төрийн бус 5 нийт 485 байгууллагатай хамтарч ажилласан байна.<br><br>Хавсралт 18 | 100% |
| **ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ: Алсын хараа 2050-ийн хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.1, 5.3.3, I үе шат (2021-2030): Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлэх үе. 5 ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ Зорилт 5.3. ЦХХХЯ-ны 2024 оны төлөвлөгөөний зорилт 7.5.** | | | | | | | |
| **ТАВ. "Хариуцсан мэдээллийн систем, дэд бүтцийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах, систем, сүлжээ, үйлчилгээнд аюулгүй байдлын шалгалт, шинжилгээ хийж, эрсдэлийг тодорхойлох, байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу үйлдэл үзүүлэх"** | | | | | | | |
| 5.1 | "И-Монгол академи" УТҮГ-ын мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журмыг боловсруулна. | - | Журмын тоо | 0 | 1 | "И-Монгол академи" УТҮГ-ын мэдээллийн аюулгүй байдлын 1 бодлого, 7 журмыг боловсруулсан, удирдлагуудаас саналыг нь авч шинэчлэн 06 дугаар сарын 17-ны өдөр батлуулж, хүчин төгөлдөр болгосон. Бүх албан хаагчдад байгууллагын нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого болон мэдээллийн аюулгүй байдлын журмуудын танилцуулга сургалтыг зохион байгуулж, сорилго авч хяналт тавин ажиллаж байна. | 100% |
| 5.2 | Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 27001:2022 стандартыг байгууллагын хэмжээнд нэвтрүүлсэн байна. | - | Нэвтрүүлсэн эсэх | 0 | 1 | Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO 27001:2022 стандарт ыг нэвтрүүлэхээр ажлын хэсэг шинэчлэн байгуулж, стандартын бичиг баримтыг боловсруулсан. Тус стандартын баталгаажуулалтын аудит хийгдэж байна. Хавсралт 19 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.3 | Mobile аппликейшинуудын харденинг шийдэл хэрэгжүүлнэ. | - | Хэрэгжүүлсэн байдал | 0 | 1 | Mobile аппликейшинуудын харденинг сайжруулах СНГ-ын хөгжүүлэгчдэд Top 10 web application security risks сургалт орсон, Mobile app hardening solution тоног төхөөрөмж худалдан авч СНГ-ын ахлах программист Б.Энхмэндийг Энэтхэг улс руу сургалт хамрагдуулсан, E-Mongolia 4.0 mobile application-г Quixxi гар утасны програмын аюулгүй байдал, менежментийн шийдэлийг ашиглан хамгаалалт хийж нэвтрүүлсэн.<br>Хавсралт 20, хавсралт-21 | 100% |
| 5.4 | Эрсдэл өндөртэй системүүдийн аюулгүй байдлыг шалгана. | - | Эрсдэл өндөртэй системийн тоо | 6 | 10 | Эрсдэл өндөртэй 10 системүүдийн аюулгүй байдлыг шалгасан.<br>Хавсралт 22 | 100% |
| 5.5 | Байгууллагын сүлжээний аюулгүй байдлыг сайжруулах шийдлүүд хэрэгжүүлнэ: Галт хана, IPS, IDS, Log management | - | Хэрэгжүүлсэн байдал | 0 | 1 | "И-Монгол академи" УТҮГ-ын Захирлын тушаалын дагуу мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах ажлын хэсгийг байгуулж, хэрэгжилтийн явцын талаар хуралдаж, МАБГ, СНГ-тай хамтран сайжруулах шийдлүүд хэрэгжүүлэн ажиллаж байна.<br><br>Хавсралт 19, Хавсралт 23 | 100% |
| 5.6 | Байгууллагын нийт болон шинээр ажилд орсон албан хаагчдыг хамруулсан мэдээллийн аюулгүй байдлын сургалт зохион байгуулна. | - | Сургалтын тоо | 2 | 8 | Байгууллагын нийт албан хаагчдад мэдээллийн аюулгүй байдлын 2 удаагийн сургалт зохион байгуулан орсон. Шинээр ажилд орсон албан хаагчдад 4 удаа сургалт орсон. Систем нэгтгэлийн газрын албан хаагчдыг хамруулсан 1. Application security awareness 2. Bridging the gap between development and security 3. Miscrosoft 365 attack surface and hardening<br>4. Top 10 web application security risks гэсэн нийт 5 удаа сургалт зохион байгуулсан. Нийт албан хаагчдад зориулж шинэлэг, шийдлүүдын сургалт зохион байгуулахаар хэлэлцүүлэн ажиллаж байна. | 100% |

Товчилсон үгийн жагсаалт:

| | |
|---|---|
| СНГ | Систем нэгтгэлийн газар |
| ЗХНГ | Захиргаа, хүний нөөцийн газар |

| | |
|---|---|
| СОНХГ | Сургалт, олон нийттэй харилцах газар |
| МАБГ | Мэдээллийн аюулгүй байдлын газар |
| ГХХАГ | Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газар |
| ЦЗХ | Цахим засаглалын хэлтэс |
| САХ | Систем ашиглалтын хэлтэс |
| ХОТХ | Хиймэл оюуны туршилтын хэлтэс |
| МХ | Маркетингийн хэлтэс |
| СХ | Сургалтын хэлтэс |
| ХҮХ | Хэрэглэгчийн үйлчилгээний хэлтэс |
| СудХ | Судалгааны хэлтэс |

*Тайлан хянасан:*
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД
*(албан тушаал)*
*Тэмдэг*

***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

.......................... /Ц.БААТАРХҮҮ/
*(гарын үсэг)*
......................
(огноо )

*Тайлан гаргасан:*
“И-МОНГОЛ АКАДЕМИ” УТҮГ-ЫН ЗАХИРАЛ
*(албан тушаал)*
*Тэмдэг*

***Төсвийн Шууд захирагч***

. . . . . . . . /Б. МЯГМАРНАРАН/
*(гарын үсэг)*
. . . . . . . . . . . . . . . .
(огноо)

АТ 853 6814786
9022080445